



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2021 оны 09 сарын 27 өдөр

Дугаар A/120

Ховд

┌ **Үнэлгээний хороо байгуулах тухай** └

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол Улсын Засгийн газраас эрх шилжиж ирсэн, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Сум багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Ховд/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: С.Мөнх-Очир - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд: Д.Дөмөгтүшиг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Бат-Эрдэнэ - Иргэний төлөөлөл

Б.Болормаа - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Д.Дариймаа - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /С.Мөнх-Очир/-д даалгасугай.

3. Дээрхи төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн хадгалахыг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Д.Дариймаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД